

**“ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ,  
НҮҮРСНИЙ ХУДАЛДАА, ТАВАНТОЛГОЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН ХҮЧИН ЧАДЛЫГ  
НЭМЭГДҮҮЛЭХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАХ СУДАЛГАА**

Улаанбаатар хот

2025 он

## ГАРЧИГ

### Агуулга

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ	5
1.1. Тухайн асуудлын мөн чанар, түүний цар хүрээ .....	5
1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд .....	6
1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл .....	6
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО	7
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ	8
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ	9
4.1. ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ .....	9
4.2. ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ .....	11
4.3. НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ .....	14
4.4. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ .....	16
4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал .....	18
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	
18	
ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ 3ҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ХИЙХ	18

## НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал” (цаашид “Аргачлал” гэх)-ын дагуу тандан судлах ажиллагааг Аргачлалын 2.1 дэх хэсэгт заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

### 1.1. Тухайн асуудлын мөн чанар, түүний цар хүрээ

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9-д “Улсын Их Хуралтай зөвшилцэж дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах” гэж тус тус заасан.

Олон Улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Улсын Их Хурал дараах олон улсын гэрээг заавал соёрхон батална” гэж, мөн зүйлийн 8.1.3 дахь заалтад “Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Заавал соёрхон батлах олон улсын гэрээний төслийн талаар хэлэлцээ хийх, олон улсын гэрээнд гарын үсэг зурах шийдвэрийг Засгийн газар энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой урьдчилан зөвшилцэж гаргана” гэж, мөн зүйлийн 11.4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 11.3-т заасны дагуу олон улсын гэрээний төслийн талаар хэлэлцээ хийх эрхийг урьдчилан авах шаардлагатай гэж шийдвэрлэсэн бол хэлэлцээ хийх эрх авах саналыг олон улсын гэрээний монголын талын төслийн хамт энэ хуульд заасан журмын дагуу Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, эсхүл Засгийн газраар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т бодлогын үндсэн 4 чиглэлийн хурээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасны нэгдүгээрт “Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина гэж тусгасан.

Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод боомт 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор тус тус нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ”, 3.3.1.1-д “Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын тувшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ”,

3.3.2.2. Хил дамнасан төмөр замын холболтыг барьж, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, ачаа тээврийн терминалуудыг байгуулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг жилд 100.0 сая тоннд хүргэнэ” гэж тус тус заасан.

### **1.2. Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдүүд**

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон баталснаар Тавантолгой төмөр зам ХХК нь “Чайна энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт” ХК-тай Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээр байгуулах бол “Эрдэнэс Тавантолгой” ХК нь Хятадын талын аж ахуйн нэгжүүдтэй нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ, уурхайн олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлэх гэрээ тус тус байгуулна.

“Тавантолгой төмөр зам” ХХК нь 2019 оны 304 дүгээр тогтоолоор үүсгэн байгуулагдсан бөгөөд 66 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 34 хувийг “Монголын Төмөр зам” ТӨХК тус тус эзэмшдэг.

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь “Эрдэнэс Монгол” ХХК 73.51 хувь, Монгол Улсын иргэд 26.43 хувь, үндэсний 487 аж ахуйн нэгж 0.06 хувь тус тус эзэмшдэг төрийн өмчит хувьцаат компани юм.

Дээрх хэлэлцээрийг байгуулснаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хилийн нэвтрүүлэх болон төмөр замын тээврийн хүчин чадал нэмэгдэж, Эрдэнэс тавантолгой ХК-ийн нүүрсний олборлолт, борлуулалт, экспорт нэмэгдэнэ.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт жил бүр 0.8 нэгж хувиар нэмэгдэх, ядуурлын түвшин буурч, нэг хүнд ногдох ДНБ-ийг 10000\$-т хүргэх, эдийн засгийн өсөлтийг 6%-аас дээш түвшинд хадгалах, инфляцыг 5%-д барих зэрэг эдийн засгийн болон стратегийн томоохон ач холбогдолтой бөгөөд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 26,43 хувийн хувьцааг эзэмшиж байгаа Монгол Улсын иргэн бүр ноогдол ашгаас хүртэх хувь хэмжээ өсөх зэрэг зерэг үр дүнд хүрэх боломжийг бүрдүүлнэ.

### **1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл**

“Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах засгийн газар хоорондын гэрээ” нь 2010 оны 06 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан бөгөөд гэрээний 15 дугаар зүйлийн 1-т “Хил дамнасан байгууламж барих, ашиглах, засварлах, хариуцан хамгаалах асуудлыг Талууд болон Талуудын эрх бүхий байгууллага хэлэлцэн тохиролцно.” гэж заасан байна.

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан.

Тус хэлэлцээр нь хоёр орны төмөр замын холболтыг урагшшуулах, Монгол, Хятадын төмөр замын тээврийн чанарыг өндөр түвшинд хөгжүүлэх зорилгоор “Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд

Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээ"-ний дагуу Гашуунсухайт-Ганцмод боомтыг холбох хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих асуудлаар дараах зүйлийг харилцан тохиролцсон байдаг. Тухайлбал: хэлэлцээрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий байгууллагыг тодорхойлох, хамтын ажиллагааны зарчим, бүтээн байгуулалтын хаалттай бүсийн хил хязгаар болон зохион байгуулалт, ажилчид, техник, тоног төхөөрөмж, бараа, тээврийн хэрэгслийг нөгөө талын бүтээн байгуулалтын хаалттай бүсэд оруулах, гаргах асуудлыг хэлэлцэн тохиролцох зэрэг болно.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр баталсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 58 дугаар тогтоолд заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг боловсруулан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд хүргүүлж, холбогдох хэлэлцээрийг хийж харилцан тохиролцсон.

Тогтоолын 2-т “Энэ тогтоолыг хэрэгжүүлэхдээ Засгийн газар хоорондын хэлэлцээр, Ажлын хэсгүүд хоорондын албан ёсны хэлэлцээний протокол, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээнүүд байгуулах, шаардлагатай бол эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийн төсөл санаачлах чиглэлээр ажиллахыг Засгийн газарт даалгасугай” гэж заасны “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

## ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Тус “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн зорилго нь хоёр талд урт хугацаанд тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгох, хоёр талын төрийн өмчтэй хуулийн этгээд хооронд байгуулах нүүрс худалдах, худалдан авах гэрээг харилцан ашигтай, нийлүүлэлт тогтвортой байх зарчмын дагуу байгуулах, нүүрсний орд дахь уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад орших юм. Ингэснээр Монгол Улсын нүүрсний олборлолт, экспортын хэмжээ нэмэгдэж, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилт эрчимжиж газрын хэвллийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх боломж бүрдэхийн зэрэгцээ дараах ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

- Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын хэлэлцээр байгуулснаар төмөр замаар экспортлох ачааны хэмжээг жилд 30 сая.тн түүнээс дээш,

Тавантолгойн ордын нүүрсний экспортын хэмжээг жилд 70 сая.тн хүртэл өсгөж, нүүрс борлуулалтын орлогыг жилд 1,5 тэрбум доллароор нэмэгдүүлэх;

- Монгол, Хятад хоёр улсын төрийн тэргүүн нарын 2014 онд баталсан “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал” хэрэгжих нэхцэл бүрдэж, Монгол Улс, БНХАУ хоорондын худалдаа, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбар, олон улс бус нутгийн хамтын ажиллагаа, Эрдэс баялаг, Аж үйлдвэр, Дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа эрчимжих, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдүүлэх;

### **ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу хоёрдугаар хэсэгт заасан зорилтыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

<b>Хувилбар</b>		<b>Зорилгод хүрэх байдал</b>	<b>Зардал, үр өгөөжийн харьцаа</b>	<b>Үр дүн</b>
1	Тэг хувилбар (шинээр зохицуулалт хийхээс татгалзах)	Өнөөгийн тулгамдаж буй асуудлууд хэвээр үргэлжлэх тул зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарагүй ч сөрөг үр дагавар нэмэгдэнэ.	Үр дүнд хүрэхгүй
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Нийтэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах, сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн цахим сүлжээ ашиглах, гарын авлага, мэдээллийн хуудас гаргах зэрэг нь зорилгод хүрэхгүй.	Тодорхой хэмжээнд зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Одоо тулгамдаж буй асуудлууд нь татвар хураамжийн бодлого, зэргээр тодорхой хязгаарлалт тогтоох зэргээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хамаарахгүй.	Тодорхой хэмжээнд зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй

4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Одоо тулгамдаж буй асуудлуудыг төрөөс шууд мөнгөн хэлбэрийн санхүүжилт үзүүлэх замаар шийдвэрлэхэд тохиромжгүй тул тус хувилбар зорилгод хүрч чадахгүй байна.	Төрөөс зардал гарах бөгөөд асуудлыг бүрэн шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэн асуудлыг шийдвэрлүүлэх боломжгүй байна.	Төрөөс зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэлжилнэ.	Үр дүнд хүрэхгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Үг асуудлыг шийдвэрлэх зорилгоор захиргааны акт, болон захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээ байгуулснаар шийдвэрлэгдэх боломжгүй бөгөөд Захиргааны ерөнхий хуульд зааснаар тухайн захиргааны шийдвэр гаргах эрх олгогдоогүй байна.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нэлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулах буюу шийдвэрлэх боломжгүй .	Үр дүнд хүрэхгүй
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хуулийн төсөл боловсруулах нь бусад оролцогч улс орнуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох тогтолцоог цогцоор шийдэх эрх зүйн орчин бүрдэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Эрх зүйн орчин бүрдүүлснээр асуудлыг бүрэн шийдвэрлэх гарц бий болно.	Үр дүн эерэг байна.

## ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

### 4.1. ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад	1.1.Ялгavarлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгavarлан гадуурхахыг хориглох эсэх		Үгүй

НИЙЦЭЖ ЭСЭХ	БАЙГАА ЭСЭХ	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг булэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	
		1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		
		1.2. Оролцоог хангах			
		1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх			Хамааралгүй
		1.2.2. Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		
		1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
		1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		
		1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		
		1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	
		2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм		
		2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	

	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм		
3.Эрх агуулагч	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалzan үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм		
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм		
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендерийн	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бурдуулэх эсэх	Тийм		

#### 4.2. ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	тийм	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдхөхийг оролцуулан)	Тийм	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	

	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм		
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх		Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополыг бий болгох эсэх		Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм		
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм		
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (ул хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	

6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	тийм		
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр баасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	тийм		
	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	
	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ

	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх		Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

Хүснэгт 3

#### 4.3. НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Эерэг нөлөө үзүүлнэ
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Эерэг нөлөө үзүүлнэ
	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй

3. Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	
	3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.3. Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.4. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.5. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
5. Нийтийн мэнд, аюулгүй байдал	5.1. Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас барагтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	5.2. Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.3. Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1. Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
	6.2. Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	
7.Гэмт нийгмийн байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	

#### 4.4. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй

	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм		
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцэд сэргээр нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.2.Хөрсийг эvdэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	тийм		
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	

7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм		

#### **4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцсэн бөгөөд энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулна.

#### **ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 58 дугаар тогтоол батлагдсан.

Дээрх тогтоолын 2-т “Энэ тогтоолыг хэрэгжүүлэхдээ Засгийн газар хоорондын хэлэлцээр, Ажлын хэсгүүд хоорондын албан ёсны хэлэлцээний протокол, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээнүүд байгуулах, шаардлагатай бол эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийн төсөл санаачлах чиглэлээр ажиллахыг Засгийн газарт даалгасугай” гэж заасан.

Иймд “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хучин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулахаар шаардлагатай.

#### **ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ХИЙХ**

Монгол Улсын Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулиар зөвхөн биржээр арилжаалах тухай заасан буюу урт хугацааны нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулах боломжгүй юм. Харин Япон, Австрали, Индонези, ОХУ, Канад, АНУ, Өмнөд Африк зэрэг орнууд уул уурхайн бүтээгдэхүүнийг форвард, спот болон урт хугацаат гэрээ зэрэг олон төрөлт гэрээний нөхцөлийг ашиглаж байна.

2023 оны 2 дугаар сараас өмнө “Эрдэнэс Тавантолгой” ХК нь худалдааны “FCA уурхайн ам” нөхцөлийг ашиглаж байсан болно. 2024 оны сүүлийн хагас жилд Хятадын нүүрсний зах зээл унаж байгаа нөхцөлд уул уурхайн бүтээгдэхүүнийг

зөвхөн биржийн форвард арилжаагаар худалдах нь учир дутагдалтай байгаа нь ажиглагдсан болно.

Иймд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн дагуу нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг байгуулах боломжгүй тул Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах замаар эрх зүйн хийдлийг залруулах боломжтой гэж үзэв.

### **ДОЛОО. ЗӨВЛӨМЖ**

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулж батлан гаргах хувилбарыг сонгох нь хууль тогтоомжид нийцсэн хамгийн үр дүнтэй гэж үзэж байна.

Тус хуулийн төсөл батлагдсанаар дараах ач холбогдолтой. Үүнд:

- Монгол Улсын нүүрсний олборлолт, экспортын хэмжээ нэмэгдэж, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилт эрчимжих;

-Газрын хэвллийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх боломж бүрдэх юм.

“Хуулийн төсөл боловсруулах” хувилбарыг зохицуулалтын хувьд бусад хувилбартай хамтатган хэрэгжүүлэх нь үр дүнгүй бөгөөд уг хувилбарыг дангаар нь хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж үзэв.

---оОо---